



ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ - ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН

# ГИНЖИЙГ ТАСАМ



2018 04

## ГИНЖИЙГ ТАСАЛ!

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдэд сурталчлан, таниулах зурагт ном

“Хөөрхөн Зүрхнүүдийн Аян” ТББ-аас санаачлан НҮБ-ын Хүн амын сан, Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр жөндөрт суурилсан хүчирхийллийг таслан зогсооход олон нийтийг уриалан дуудах “Гинжийг тасал” нөлөөллийн кампанит ажлын хүрээнд энэхүү зурагт номыг гаргав. Олон нийт тэр дундаа хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдэд гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийг зөв үнэлэх, таних, урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэл өгч, эрсдэлт нөхцөлд байгаа бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд хэрхэн тусламж үйлчилгээ авах, өөрийгөө болон ойр дотны хүмүүсээ хамгаалах, хэрэглээ болгоход зориулагдсан болно.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 10 гол өөрчлөлтийг харуулсан инфографикийг НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс боловсруулан гаргав.

Зохиолыг бичсэн:

Б.Оюундарь, Клиник нийгмийн ажилтан

П.Энхчимэг, Сэтгэлзүйч

А.Хонгорзул, Сэтгэлзүйч

Зураач: Н.Билгүүн

Хоёр дахь хэвлэл

2018 он



976-70159688

Итгэл охин айлын том хүүхэд бөгөөд ээж, аав, дүү нарын хамт амьдардаг. Ээж, аав нь мал ахуйдаа ихэнх цагаа зарцуулдаг энгийн нэгэн гэр бүл.





Аав нь мал ахуйгаа зарцуулах,  
эд хөрөнгө худалдаж авах гээд  
гэрийн бүхий л өмч хөрөнгөтэй  
холбоотой асуудлыг ганцаараа  
шийдэж, өөрт нь таалагдахгүй  
зүйл гарвал эхнэр, хүүхдүүдээ  
бүгдийг загинаж, хэл амаар  
доромжилж, заримдаа гар хүрэх  
тохиолдолд ч гардаг байлаа.





Хэдэн жилийн дараа Итгэл охин сургуулиа ч төгсөж, ангийнхаа хөвгүүнтэй дотносож, удалгүй гэрээ барьж айл гэр болон өрх тусгаарлалаа.



Хэдий айлын гэргий болсон ч, ажил хийж хамт олны дунд бүтээлч өрнүүн амьдрах хүсэл Итгэлийн зүрхнээс салсангүй.



Ажилд орох тухай ярих бүрд чадваргүй, ямар ч ашиггүй гэж хэлдэг нөхөртөө хүсэл мөрөөдлөө хэрхэн ойлгуулахаа олон дахин бодож гунигладаг байв.



## СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



Нэгэн өдөр зориг гарган  
бүртгүүлсэн ажилдаа  
тэнцсэнээ гэртээ яаран ирж  
нөхөртөө сэтгэлээ барьж ядан  
хэлэв.

Гэнэт тэнгэр хөмрөв үү гэлтэй  
зүйл болов. Нүүр халуу шатах  
шиг. Чанга чангаар хашхирах  
дуу анзааран сонсвол ...



Чи хэнээс асууж  
шийдвэр гаргав?  
Ар гэрийн ажлыг хэн хийж,  
гэр орноо хэн харах юм бэ?  
Чи ажил хийх гэж биш  
олон дунд очиж аальгүйтэх  
гээ биз!!!



Маргааш өглөө нь:

Итгэлийн нүүрнээс илүү сэтгэл нь хөндүүрлэн байгааг анзаарлаа.

Хэнд хэлэх вэ? Хэнтэй сэтгэлээ хуваалцах вэ? Эцэг, эх, ах, дүү нар энэ бол өөрийн чинь л сонголт гээд намайг буруутгах байхдаа гэсэн айдас, зовнилоор дүүрэн.




Саалийн зэлэн дээр очиж, үнээгээ саангаа хий дэмий үйлж, өөрөө өөртэйгөө ярьж байгаад саахалт айлын эгчийг хажууд ирснийг анзаарсангүй.



Чиний царай  
зүс яагаа вэ? Гэр бүлд нь асуудал  
гараа юу? Гэр бүлд асуудал, зөрчил гарч л  
байдаг. Гэхдээ түүнийг хэн нэгнийгээ зовоож,  
дарамтлаж шийдэж болохгүй. Гэр бүлийн зөрчил  
нь дотоод асуудал, ичгэвтэр зүйл, миний л  
амьдрал гэж бодон хүнд хэлж, тусламж авч  
чадахгүй явсаар амь нас, эрүүл мэндээрээ  
хохирсон олон эмэгтэйг  
эгч нь мэднэ.

Миний дүүгийн харц гундаж, нүд  
хөхрөөд, нэг зүйл хэлэх шиг.  
Чамд хэрэгтэй хүнийг би мэднэ. Хүний нууцыг  
бат хадгалдаг мэргэжилтэн юм гэсэн шүү  
уулзаад үзээрэй. Иргэн бид ч гэсэн гэр бүлийн  
хүчирхийллийг мэдвэл зохих газар нь  
мэдээлэх эрхтэй хүмүүс шүү дээ.



Ингээд хөрш эгчийн  
зөвлөснөөр нөхөртөө шалтаг  
хэлэн сумын төв рүү нийгмийн  
ажилтантай уулзахаар явав.





Нийгмийн ажилтны өрөөнд:

Сайн, та наашаа суугаач.

Та зөв газраа ирсэн байна. Гэр бүлийн хүчирхийлэл бол ойр дотнын хүн чинь хяналтаа тогтоож, эрхшээлдээ оруулахын тулд санаатайгаар, сонгож хийдэг үйлдэл юм.

Сайн байна уу?

Надад таны зөвлөгөө, дэмжлэг хэрэгтэй байна. Нөхөр бид хоёрын дунд нэлээд зөрчил үүсээд. Яах учраа олохгүй явна.




Гэр бүлийн хүчирхийлэл нь  
**ДАЛД, ЦООЖТОЙ ХААЛГАНЫГ**  
**ЦААНА, ДАХИН ДАВТАГДДАГ,**  
**УЛМААР ДААМЖИРДАГ** үзэгдэл  
учраас бусдаас дэмжлэг авах, ил гаргахад  
хүнд байдаг. Хүн бүр л танай саахалт  
айлын эгч шиг нэгнээ дэмжиж тусалдаг  
бол хамтын хүчээр бид таслан  
зогсоож чадна.

Би чамайг энд ирж,  
уулзаад явсан тухай  
нөхөрт чинь болон өөр хэнд ч  
хэлэхгүй, нууцыг чанд хадгална.  
Энэ бол миний мэргэжлийн ёс зүй,  
мөн хуулиар хүлээсэн үүрэг.

Би яг одоо ч гэсэн  
гэр орондоо болсон  
зүйлийн талаар танд  
ярьж байгаа маань зөв  
эсэхэд эргэлзэж, бас  
түгшиж байна.


Хэрэв манай  
нөхөр мэдвэл  
юу болох бол.....





Нөхөр маань сайн хүн л дээ.

Би л дураараа загнаад  
ажилд орно гээд...



Хэн нэгэн хүн  
ямар нэг зүйл хийсэн нь  
түүнийг гар хүрч шийтгэж болно гэсэн  
үг биш. Тэгээд ч хүчирхийлэл гэдэг зөвхөн  
гар хүрэхээр хязгаарлагдахгүй.

\*Үл тоох, үл хайхрах, үг хэлээр гутаан  
доромжлох

\*Мөнгө санхүүгээр хязгаарлах


\*Нийгэмших, хөгжих боломжийг хаах

\*Бэлгийн хүчирхийлэл ч мөн багтана.

Та ажил хийх эсэхээ өөрөө  
шийдэх эрхтэй, бие даасан хүн. Ажил  
хийе гэж хэлсний чинь төлөө зодож,  
дарамтлах нь байж болошгүй.

Таныг ажил хийе гэхээр зодсон нь  
зөвхөн шалтаг. Харин цаад учир шалтгаан нь  
таныг өмчилж, зөвхөн өөрийнхөө эрхэнд  
байлгах гэсэн аминч үзэл юм.





Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаа аюулын зэргийг үнэлж, хэрэв аюулын зэрэг өндөр бол та болон танай гэр бүлд байгаа бусад гишүүдийг ч хамгаалалтад авах журамтай.

Та буцаж очихоос айж, бас хүсэхгүй байгаа бол бид танд тусалж, хамгаалалтад авъя.

Би чинь хүчирхийллийн нэлээд хэдэн төрлийг хэвийн зүйл мэт бодон амьдарч байгаа юм байна. Гэхдээ буцаад очихоор намайг сумын төвд удлаа гээд уурлах байх та хурдхан яриарай. Би яаруу явна.

Өнөөдөртөө гайгүй байх, гэртээ харья. Нээрээ хэдэн жилийн өмнө хөрш ах манай гэрийн хажуугаар өнгөрч явахдаа цагдаа дуудсан юм билээ. Цагдаа ирээд "яагаад хөршийнхөө амгалан байдлыг эвдээд байна" гээд айлын ах дуудлага өгсөнийг бариад өгсөн, бас "гэр бүлийн маргаан байна" гээд яваад өгсөн. Түүнээс хойш нөхөр ч айлын ахтай түнжин хагарч, тэд ч дахин цагдаа дуудаагүй.





Нээрээ үү?

Энэ ганцхан надад л тохиолдоод байгаа асуудал гэж боддог болохоороо хүнд хэлж ярихаас санаа зовдог.



Шинэ хуулиар гэр бүлийн хүчирхийллийн мэдээлэгчийн нууцлалыг маш сайн хадгалж байгаа. Мөн цагдаагийн ажилтан хүчирхийлэл үйлдэгчийг архи хэрэглээгүй байсан ч түр саатуулах үүрэгтэй болсон. Та гэртээ харих гэж байгаа бол аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах талаар хоёулаа хамтдаа ярьж төлөвлөө. Та хэрэгжүүлээрэй.

Тань шиг хүчирхийлэлд өртсөн хүмүүст үзүүлэх үйлчилгээг мөн хуулиар тодорхой заасан байгаа. Та сэтгэлзүй, эмнэлэг болон халамжийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой.

Долоо хоног бүр манайд эмэгтэйчүүдийг дэмжих бүлэг ажилладаг. Та энд оролцож, бусад эмэгтэйчүүдтэй ярилцаж болно.



Хуулийн шинэчлэл бидэнд олон боломж олгосныг мэдэх үнэхээр таатай байна.

Биднийг хамгаалах мэргэжилтнүүд засаг дарга, цагдаа, эмч, нийгмийн ажилтан хуулиар үүрэг хүлээн хариуцлагатай ажиллаж байна.




ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ  
ҮНДЭСНИЙ ТӨВ



НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛАГАН  
ХҮН АМЫН САН



ШИНЭЧЛЭН БАТЛАГДСАН ГЭР БҮЛИЙН  
ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ  
**ХУУЛИЙН  
10 ГОЛ ӨӨРЧЛӨЛТ**



**1** **ХОХИРОГЧДЫН ДИЙЛЭНХ НЬ ХУУЛИЙН ХАМГААЛАЛТЫН ГАДНА ҮЛДДЭГ БАЙДЛЫГ ӨӨРЧИЛСӨН.**



**Гэр бүлд амьдарч байгаа хүн:**

- Эхнэр, нөхөр, гэр бүлийн гишүүн;
- Хамтран амьдрагч;
- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асран хамгаалалтад байгаа.

**Тусдаа амьдарч байгаа**

- Төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд;
- Төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү.

**Гэр бүлийн харилцаатай байсан**

- Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр;
- Хамтран амьдарч байсан хүн;
- Хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан хүн.

**2** **ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГДСЭН ЭСХҮЛ ҮЙЛДЭГДЭЖ БОЛЗОШГУЙ БОЛ:**

ЗААВАЛ МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ



Бүх шатны боловсролын байгууллагын багш, сургуулийн ажилтан, бусад ажилтан



эрүүл мэндийн, нийгмийн, хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан ажилтан



баг, хороо, сум, дүүргийн холбогдох албан тушаалтан



төрийн албан хаагч



төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын ажилтан

МЭДЭЭЛЭХ ЭРХТЭЙ



хувь хүн




байгууллага

ХҮҮХДИЙН ЭСРЭГ  
ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААР  
МЭДСЭН ХЭН Ч БАЙСАН  
ЗААВАЛ  
МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ.



### 3 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫГ ТОДОРХОЙ ЗААСАН.



МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТТАН ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ДАРУЙ АВЧ, МЭДЭЭЛЭЛ ӨГСӨН ХҮНИЙГ НУУЦЛАХ ҮҮРЭГТЭЙ.



ХАРЬАЛАЛ ХАРГАЛЗАХҮЙ ХАМГИЙН ОЙР БАЙГАА  
**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД**



ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЗЭГҮЙД  
**СУМ, ДҮҮРЭГ, БАГ, ХОРООНЫ ЗАСАГ ДАРГАД**

### 4 ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ТОДОРХОЙ БОЛСОН.



Мэдээллийг хүлээн авмагц таслан зогсоох;



Баривчлах;



Хохирогчийг Нэг цэгийн үйлчилгээ, хамгаалах байранд хүргэх;



Орон байранд нэвтрэх, гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах;



Галт зэвсэг, зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг хураан авах;



Нэг цэгийн үйлчилгээ, хамгаалах байр байхгүй бол төрөл садан, ойр дотных нь хүнийг түр хамгаалалтад өгөх;



Аюулын зэргийг үнэлэх;



Хүчирхийлэл үйлдэгч тавьсан шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсхүл эсэргүүцсэн бол албадлага хэрэглэх;



Гэрээс бичиг баримт, шаардлагатай хэрэглэний эд зүйлээ авахад нь туслах.

### 5 ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙГ ТУСГАЙ ХАМГААЛАЛТААР ХАНГАНА.



Цагдаагийн албан хаагч аюулын зэргийн үнэлгээ хийнэ.

Аюулын зэрэг "дунд", "өндөр" бол эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг харгалзахгүй хүүхдийг түр хамгаалалтаар хангах арга хэмжээ авна.

Түр хамгаалалтаар хангах арга хэмжээ авагдсан үед хүчирхийлэл үйлдэгч тэжээн тэтгэх үүргээсээ чөлөөлөгдөхгүй.

### 6 ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨРӨЛЖҮҮЛЭН ХУУЛЬЧИЛСАН.



эмнэлгийн тусламж, үйлчилгээ;



нийгмийн халамжийн үйлчилгээ;



хүүхэд хамгааллын үйлчилгээ;



холбон зуучлах үйлчилгээ.



аюулгүй байдлын хамгаалалт:

- Түр хамгаалан байрлуулах;
- Нэг цэгийн үйлчилгээ;
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээнд хамруулах.



сэтгэл зүйн үйлчилгээ:

- Сэтгэл зүйн зөвлөгөө;
- Сэтгэл заслын үйлчилгээ.



эрх зүйн тусалцаа:

- Эрх зүйн зөвлөгөө;
- Өмгөөллийн үйлчилгээ.



